

**ХЯТАДЫН МИН УЛСААС МОНГОЛЫН ТАЛААР
ЯВУУЛЖ БАЙСАН УЛС ТӨРИЙН БОДЛОГООС**

(XVI зуунаас XVII зууны эхний хагас)

Н. Ариунгуа

Хятадын Мин Улсаас Монголын талаар шатлан явуулж байсан бодлогыг бүх талаар судлах нь чухал бөгөөд энэ нь нарийн судлагдаагүй асуудлуудын нэг юм. XVI зуунаас XVII зууны эхний хагаст Монгол Хятадын хоорондын улс төрийн харилцаа, тухайлбал Мин улсаас Монголын талаар явуулж байсан төрийн бодлогыг эрдэмтэд судлахдаа гол төлөв эдийн засгийн талаас нь авч үзжээ. Чингэх нь нэг талаар ойлгомжтой юм. Учир нь Мин улсаас хөрш зэргэлдээ нүүдэлчин улс орнуудын эдийн засгийн сул дорой байдлыг далимдуулан худалдаа, түрэмгийлэл хоёрыг хослуулсан бодлогыг явуулж байсан байна. Мин улс монголчуудад эдийн засгийн дарамт үзүүлэхээс гадна улс төрийн явуулгыг өргөнөөр хэрэглэж байсныг түүхийн баримт материалаас харж болох юм. XVI зуунаас XVII зууны эхний хагас дахь монгол-хятадын харилцаанд холбогдох мэдээ материал “Мин ши” (Мин улсын түүх), “Ван ли угун лу” (Ван ли хааны байлдааны гавьяаны тэмдэглэл), “Мин шил у” (“Мин улсын үнэн тэмдэглэл”) зэрэг түүх шастирт байдаг юм. Тухайн хятад сурвалжид бичигдсэн материалуудад ихээхэн эргэлзээтэй, үнэнийг шууд гуйвуулсан зүйл багагүй байна. Иймээс тэдгээр материалыг ашиглахдаа шүүмжлэлтэй, нарийн судалгаатай хандах нь зүйтэй юм. Хятад-монголын улс төрийн харилцааны талаар тэдгээр зохиолд тусгасан нь гол төлөв баруун гарын зонхилогч түмэдийн алтан хан Мин улстай харилцаж байсан тухай өгүүлсэн байдаг. Дээрх зохиолуудад Мин, Монголын улс төрийн харилцаанд холбогдох зарим сонин материалууд тааралдаж байна. Тухайлбал түмэдийн Алтан ханы хатан Юнгэн Мин улстай тогтоож байсан хэлхээ холбооны талаар багагүй материалыг хятад хэлээр үзэж болно. XVI-XVII зууны Хятадын түүхийн зохиолуудад Юнгэн хатны талаар нэлээд тодорхой тэмдэглэсэн боловч тэдгээр мэдээ сэлтийн дотор тэрхүү хатны жинхэнэ нэрийг нь тэмдэглээгүй, зөвхөн Сан нянцзы (3-р хатан) хэмээн нэрлэсэн байна. Хятадын судар бичигт гарч буй Сан нянцзы гэгч нь Алтан ханы 3-р хатан Юнгэн болохыг бидэнд олдож буй монгол, хятад хэл дээрх түүхэн зохиолыг харьцуулан судалсан үр дүнгээс мэдэж болох байна. “Эрдэнийн тунамал шастирт” Алтан ханы Юнгэн хатны тухай мэдээ байдаг боловч чухам Алтан ханы хэддүгээр хатан болохыг дурдаагүй байна. Дээрх зохиолд Алтан хан 1568 онд Ойрд руу дайтахаар явахдаа

хатан Юнгэнийг авч явсан ба тэр нь замдаа хүүхэд төрүүлж төрсөн хүүхдийг Бутшир хэмээн нэрлэсэн тухай мэдээнээс өөр онцын зүйл байдаггүй билээ.¹ Юнгэн хатан Сан нянцзы болохыг “Ван ли у гун лу”-д “Сан нянцзы Бутширийн эх хэмээн бичсэнээс мэдэж болох юм”² Юнгэн хатан Мин Улстай хэлхээ холбоо тогтоож байсан бөгөөд Мин улс тэрхүү хатныг монголчуудын хүчийг дотроос нь задлан сарниулах бодлогодоо ашиглаж байсан нь илэрхий. Тэр үед Өмнөд монголын баруун гарын зонхилогч Алтан хан олон жилийн турш Хятадтай худалдаа хийхийг эрмэлзсэн боловч эс бүтэхэд байн байн уулгалж довтолдог байв. Тухайн үед Монголын хаан Түмэн засагт Мин улсын түрэмгийллийг эрс няцааж тусгаар тогтнолоо хамгаалж байжээ. 1571 онд Мин улсын засгийн газар Алтан ханы шаардлагыг арга буюу хүлээн авч монголчуудтай худалдаа хийхийг зөвшөөрчээ. Мин улс монголчуудтай хэдий найрамдалт харилцаа тогтоосон боловч хятадын хааны гол зорилго нь монголчуудын хүчийг сарниулж, улмаар хоёр талын харилцааны тэнцвэрийг өөрийн талд ашигтайгаар эргүүлэхэд элдэв арга сүвэгчилж байсанд оршино.

Юнгэн хатан алтан хааны худалдаа, алба барих хэргийг эрхэлж байсан нь Мин улсад их ашигтай хэрэг болсон тухай Хятадын түүхийн нэгэн зохиолд тэмдэглэхдээ: “Сан нянцзы худалдаа, алба барих хэргийг эрхлэх болсноор манай хил хязгаар амгалан тайван боллоо”³ гэжээ.

Юнгэн хатан цэргийн талаар эрх мэдэлтэй байсан байна. Алтан ханы нас нөхцөний дараа ахмад хөвгүүн Хунтайж түүний орыг залгамжилснаар Юнгэн цэргийн хувьд эрх мэдэлгүй болсон учир Мин улсын цэргийн эрхтэн Чжэн Лоу гэгч Сан нянцзыг Монголын эртний уламжлалт ёсыг дагаж Хунтайжтай суухыг ятгаж байжээ.⁴ Улмаар Сан нянцзы дургүй байсан боловч арга буюу түүнтэй суусан байна. Удалгүй Хунтайж нөжид (шалиг) самуунд нэрвэгдсэн учин Юнгэн түүний шилдэг цэргийг авч эзэмшил газрынхаа баруун хязгаарт шилжин суужээ. Түмэдийн зүүн хязгаарыг Алтан ханы хүү Чилэгтэй захирч байжээ. Юнгэн хатны хүү Бутшир, Чилэгтэй хоёр тэр үед эрх мэдлээ булаацалдаж тэмцэлдэж байсан ажээ.

Чилэгтэй өөрд нийцсэн болзлыг Хятадын талд тулган хүлээлгэх зорилгоор Хятадын хилийг уулгалж байх үед Юнгэн Мин улс руу элч явуулан мэдээ сэлт дамжуулж байжээ. “Чилэгтэйг шаардан зүүн чигт буцаах гэсэн маань бүтсэнгүй... хэрэв чадвал элч явуулж хайртай хүү Бутширыг суулган олон аймгийн ноёдыг цөмийг хуваарилан өргөмжлөөд, Хан улс 5 шаньюй байгуулсантай адил тэднийг харилцан өөр зууран эвдрэлцүүлэн хэн дийлж, хэн дийлэгдэхийг харж загасчин мэт ашиг олох нэгэн арга юм”⁵ гэжээ. Ийнхүү Мин улсын засгийн газар алтан ханы 3-р хатан Юнгэнийг өөрийн талд татан оруулж монголчуудын эсрэг турхиран ашиглаж байжээ.

Хятадын эзэн хаант төрөөс нүүдэлчдийн эсрэг явуулж байсан дээр цагийн уламжлалт бодлогын бас нэг жишээ бол алтан ханы ач хүү Бага ач хэмээн нэрлэгдсэн Түвэд тайж түүнтэй эвдрэлцэн Мин улсад урван орсон явдлыг ашиглахыг оролдож байсан явдал мөн.

¹ “Эрдний тунамал шастир”. 13-р тал

² “Ван ли гүн лу” 223-р тал

³ Цзуй вэйлу” (Гэмт хэргийн тухай тэмдэглэл), “Сан нянцзы чжуан”, (“Сан нянцзыгийн намтар”), 28-р цзюань

⁴ “Мин ши” (“Мин улсын түүх”) “Чжэн луо чжуан”, (“Чжэн лоугийн намтар”), 22-р цзюань

⁵ “Ван ли у гун лу”, 223-р тал

Ван чингү хэмээх хязгаарын сайд Түвэд тайжийг Алтан ханы эсрэг явууллагад ашиглах бүхэл бүтэн төлөвлөгөө зохиожээ. Ван Чингүгийн төлөвлөгөө ёсоор “хэрэв Алтан хан цэрэг дайчлан, ач хүүгээ хүчээр авах гэвэл Алтан ханы нийслэлд хоргодон байгаа хятад оргодлуудаар солио хийх. Хэрэв Алтан хан энэ болзлыг эс зөвшөөрч халдан довтлох гэж сүрдүүлбэл Бага ачийг ална гэж алтан ханыг айлгах, хэрэв Алтан хан Бага ачийг алахаас эс айвал “Хан улс хүннүгийн хөвгүүнийг барьцаа болгон авсан хэргийг үлгэрлэн дуурайж явуулсугай. Хэрэв түүний (Бага ачийн-Н.А.) хуучин харьяат ардаас нааш ирж дагаар орвол Хан улс хараат улсыг Уханд суулгасан явдлыг дуурайж дагаар ирэгсдийг бага ачаар хамруулъя. Хожмын өдөр аньда (Алтан хан-Н.А.) хөгшрөн үхсэн хойно Хунтайж залгамжилсан ч бүх аймгийг дагуулж чадахгүй байж магад, тэгвэл бид Бага ачаар тэднийг захируулан хэргэм зэрэг өргөмжилж хэрмийн гадна нутаглуулж түүний байдлыг үзсүгэй. Тэгвэл хуучин үлдсэн аймгууд эрх биш дагаж ирнэ... улмаар Хунтайжтай алалдуулбал бид тэдний байдлыг ашиглан захирч болох юм”⁶ гэжээ.

Мин улсын Засгийн газар дээр төлөвлөгөөнүүдийн нэгдүгээрийг илүү сонирхож байжээ. Яагаад гэвэл уг хэрэг гарахаас өмнө Хятадын оргодол хүмүүс Цю фу, Чжоу Юань зэргийг Алтан ханд Хятадыг довтлох төлөвлөгөө зохиож байна гэж хардан тэднийг олзлохыг завдаж байсан бөгөөд тэдгээрийг баривчилсан хүнд 300 лан алт шагнаж Санпинь угуань цол зэргийг олгоно⁷ гэж зарлаж байжээ. Хятадын тал 1571 оны 1-р сард Бага ачийг алтан ханд дагаж орсон хятадын оргодлуудаар солих авч болохыг албан ёсоор мэдэгджээ.⁸ Алтан хан Юнгэн хатны ятгалгаар Хятадын болзлыг хүлээн авчээ.

Мин Улсын Засгийн газар Хан улсын үед хүннү нарын эсрэг явуулж байсан “Нүүдэлчдийг ашиглан нүүдэлчдийг довтлох”, “Нүүдэлчдийг ашиглан нүүдэлчдийг баримтлан захирах” бодлогыг хэрэгжүүлэхийг оролдсоноос гадна Монголын нутаг дэвсгэр рүү уулгалан довтолж байжээ. Мин улсын цэрэг жил бүрийн намар Монголын хилийг довтолж 380 ли, заримдаа 580 ли газраар цөмрөн орж, билчээр нутгийг шатааж, монголд ихээхэн хохирол учруулж байжээ. Тухайлбал 1560 онд Датунь цэргийн эрхтэн Лю хань гэгч Монголын нутаг руу дайрч Байшин хотыг шатааж 150 хүнийг олзлон авчээ.⁹ Алтан хан энэхүү түрэмгийллийн талаар Мин улсын засгийн газарт хандаж: “сүүлийн жилүүдэд Мин улс бүх хилийн дагуу уулгалж олон тооны хүнийг алж, адуу малыг өөрийн талд хөөн оруулж байна”¹⁰ гэж анхааруулж байжээ.

Ийнхүү Мин улс нүүдэлчдийн эсрэг эзлэн түрэмгийлэх бодлого явуулж, нүүдэлчид арга буюу өөрсдийгөө хамгаалан, тусгаар тогтнолоо хадгалж байжээ.

⁶ “Ван ли у гун лу”. 158-р тал; Four documents relating to sino-mongol peace of 1570-1571 by Henry Serruys CICM, monumenta serica vol XIX, p 8-9.

⁷ “Ван ли у гун лу”, 157-р тал

⁸ Four documents relating to sino-mongol peace of 1570-1571 by Henry Serruys, vol XIX, p 17.

⁹ Мин ши “Да дан чуан” (“Да даны шастир”) 8457-р тал

¹⁰ “Бэй дишунь и ван аньда Сэ бяб” (“Хойд ди-гийн Аньдагийн талархалын бичиг”) 1-р цзюань, 1-р дэвтэр

ИЗ ПОЛИТИКИ МИНСКОГО КИТАЯ ПО ОТНОШЕНИЮ К МОНГОЛИИ В XVI ВЕКЕ И ПЕРВОЙ ПОЛОВИНЕ XVII В

Резюме

Политика Минского Китая по отношению к Монголии сравнительно малоизученна. Ученые, занимающиеся данной проблемой, главным образом рассматривают экономическую сторону политики минской династии. Это вполне объяснимо. Ибо экономическое давление, притеснение являлись составной частью политики Китая. Вместе с тем, как подчеркивает автор статьи, политические акции, такие как сеяние раздора между монгольскими феодалами, использование противоречий между ними, опустошительные набеги на пограничные районы Монголии имели место и занимали не последнюю роль в попытке осуществления китайцами политики "разделяй и властвуй". Автор подчеркивает, что именно политика минской династии во многом являлась источником напряженных отношений между Монголией и Китаем в рассматриваемый период, включая частые конфликты и военные столкновения.

В статье приводятся некоторые новые сведения подтверждающие сущность этой политики.